

МОНГОЛ ҮНДЭСТНИЙ НҮҮДЛИЙН ЭДИЙН ЗАСАГ БОЛОН УЛАМЖЛАЛТ ЭКОЛОГИЙН ҮЗЭЛ

Баатар*

Урт хугацааны нүүдлийн эдийн засгийн нөхцөл доор, мал аж ахуй эрхэлсэн монголчууд их байгальтай харьцах ба амьдрал үйлдвэрлэлийн явц дундаа нүүдэлчин үндэстний өвөрмөц байгаль орчны уламжлалт экологийн үзлийг бий болгожээ. Хүн төрөлхтөний нийгэм бүхий тэдний амьжиргаа, хөгжилд түшиглэж өнөө үед байгаль орчныг хүндэтгэх монголчуудын энэхүү эртний бөгөөд борогжуун үзэл нь маш их бодит ач холбогдолтой юм.

Байгалийг хамгаалах, экологийн орчныг хамгаалах нь одоо үеийн соёл иргэншлийн нөхцөлд сая бий болсон үзэл биш, мөн хүмүүс байгалийг их хэмжээгээр эвдэж, байгаль орчны сөргүү дайралтыг амссаны дараахь оюуны тунгаалт ч биш. Аль эрт “Тэнгэр нэтийж газар сунзарсан” их хээр талд ус өвс даган нүүдэллэн мал аж ахуй эрхэлж байсан монголчууд, байгаль орчныг хамгаалахын чухал чанарыг мэдэж олсон юм. Өөрөөр хэлбэл, хэдийгээр эртний монголчуудын дунд экологийн орчныг хамгаалах гэсэн үг байгаагүй боловч, байгалийг хамгаалах, бодит байгаа байдлаар нь түүнийг өөрийн үндэстний уламжлалт соёлын чухал нэг өв болгож чадсан юм.

Монголчуудын түүхэнд эзэгнэж байсан ан агнах болон нүүдлийн эдийн засаг нь байгалийн эдийн засгийн цар хүрээнд багтана. Нүүдлийн эдийн засгийн үйлдвэрлэх хүчний бүтцээс үзвэл, үйлдвэрлэлийн хэрэгсэл нь бэлчээр бөгөөд хөдөлмөрлөгч нь мал малжихаар дамжин байгалиас амьдрал ба үйлдвэрлэлийн хэрэгслээ олборлодог. Хүн болгон байгалийн харилцан үйлдлийн явцад, мал сүрэг нь дамжуулагчийн үйлдэл гаргаж, хүмүүс байгалийг өөрчлөх, салшгүй нэгэн хөдөлмөрийн багаж болсон байна. Ердөө хөдөлмөрийн этгээд болон хөдөлмөрийн хэрэгслийн харилцаа бол тогтмол байдаг. Гэтэл, монголчуудын нүүдлийн эдийн засгийн үйлдвэрлэлийн хүчний бүрэлдэхүүнийг бодитойгоор шинжвэл, тухайн үеийн тэнгэрийг түших бүдүүлэг мал аж ахуйн нөхцөлд бэлчээр, мал сүрэг гэсэн энэхүү нүүдлийн эдийн засгийн хөдөлмөрийн этгээд болон хөдөлмөрийн хэрэгслийн харьцаа нь тогтмол биш, “Харилцан орлож” болдог байжээ. Өөрөөр хэлбэл, мал аж ахуй эзэгнэхээс яривал, бэлчээр бол үйлдвэрлэлийн хэрэгсэл аж ахуй эрхлэгчийн нийгмийн хөдөлмөр

*Баатар - Өвөр Монголын Зүүн хойт Ази судлалын хүрээлэн, дэд профессор

оруулалтаас яривал, мал сүрэг нь мөн шууд үйлдвэрлэлийн хэрэгсэл болдог байна. Шууд үйлдвэрлэлийн хэрэгсэл болсон мал сүргийн үржилт өсөлт нь дахин бэлчээрийн их бага хийгээд сайн мууд түшиглэнэ. Иймээс мал аж ахуйн эдийн засгийн үйлдвэрлэх хүчнийг дээшлүүлбэ гэвэл, юуны өмнө бэлчээрийг өргөн эзэмшиж, мөн түүнийг хамгаалахыг урьтал болгох хэрэгтэй. Энэ утгаас үзвэл, бэлчээр нь мал аж ахуйн эдийн засгийн гол хөдөлмөрийн хэрэгсэл болдог байна. Байгаль, мал сүрэг, хүн гурвын харилцан түшиглэлцэж, харилцан хамааралт харьцаа нь: хүн мал сүрэгт түшиглэж үйлдвэрлэл амьдралаа аргааа, мал сүрэг нь бэлчээрт түшиглэж үржиж өсөх, бэлчээр нь дахин хүний чармайлтанд түшиглэж хамгаалагдах. Даруй хүн –мал сүрэг -бэлчээр -хүн. Хүн бол үйлдвэрлэлийн хүчин дотор хамгийн үндсэн, хамгийн идэвхтэй элемент, үйлдвэрлэлийн явцын гол цогц /объект/ мөн бөгөөд энэ гурвын харьцааг зохицуулахад хүний экологийн үзэл баримтлал, магадлал нь голлох үүрэгтэй юм.

Нүүдлийн эдийн засагт мал сүрэг нь “шууд үйлдвэрлэлийн хэрэгсэл хийгээд хөдөлмөрийн хэрэгслийн хос чадавхи үйлдлийг дайчлахаас гадна бас хөдөлмөрлөгчийн амьдралын хэрэгсэл болон солилцож болох таваарын үйлдлийг гаргадаг юм. Мал сүрэг нь эзэгнэгчийн олон талын үйлдвэрлэл амьдралын эрэлт хэрэгцээг хангаж болдог юм байна. Жишээлбэл, морь, тэмээ бол хээр талын хамгийн зохистой зам тээврийн багаж /үйлдвэрлэлийн хэрэгсэл/, үхэр, хонины мах бол монголчуудын гол идэш, сүү бол тэжээл баялагт байгалийн экологийн ундаа. Арьс, ноолуурын хэрэгцээ нэн өргөн, түүгээр хувцас хунар, хөнжил дэвсгэр, ташуур ногт, эмээлийн хэрэгсэл хийж болно. Монголчуудын суудаг гэр нь мөн ч ноосоор хийсэн юм. Малын баасаар аргал түлш хийдэг. Хэрэв түүнийг солилцоонд хэрэглэвэл, тэр нь таваар болчихдог юм байна. Үйлдвэрлэлийн хүчний хөгжилтийн төвшнийг хэмжих объектив баримжаагаар яривал, үйлдвэрлэлийн багажийн орчин үежсэн болон хоцронгуйн хэмжээ нь хүн төрөлхтөний байгалийг эзэмших чадварын гол хэмжүүр болно. Үүнийг мал аж ахуйн эдийн засагт оруулбал, түүний “хэмжүүр” нь бэлчээрийг эзэмшсэн хэмжээ, ашиглаж хамгаалсан байдал зэрэг болно. Бэлчээрээ алдсан буюу бэлчээр эвдэгдэх нь даруй үйлдвэрлэлийн хэрэгслээ алдаж эвдсэн явдал мөн. Тиймээс тэд нар тал нутаг бэлчээрээ өөрийн амь шиг хайрлаж, хамгаалдаг юм. Монголчууд тал нутгийг магтан дуулдгийн учир нь зөвхөн тал нутаг тийм ч гоёдоо байх биш, харин нэн чухал нь тал нутаг тэд нарт амьжиргаа, амьдрал, үйлдвэрлэлийн нөхцөл, жич

цаашлан бүхий л амь биеийг нь олгосонд байх юм. Иймээс нүүдлийн эдийн засгийг экологийн эдийн засаг гэж үзэж болно. Экологийн эдийн засаг байснаас хүмүүсийн экологийн үзэл суртал үүссэн юм.

Монголчуудын нүүдлийн эдийн заӨвөр Монголын Зүүн Хойт Ази судлалын хүрээлэн сгийн түүхэн хугацаанд ан агнах нь тун чухал нөхвөр болж байсан юм. Зэрлэг амьтныг агнах талаар маш олон хориг цээр болон нийтээр баримтладаг бичигдээгүй хууль ёс бий болсон юм. Ан агнахад орон зайн талаар маш их журамтай. Агнах цагийн талаар ярихад жил бүрийн гуравдугаар сараас аравдугаар сарын хооронд их хэмжээгээр хүрээ ан хийдэггүй. Учир нь билгийн улирлын 3-10-р сарын хооронд амьтдын ноос ноолуур нь ургаж амжаагүй, эцэнхий туранхай, энэ үед зэрлэг амьтныг алж агнах нь нэг зүйлийн эх баялгийн сүйтгэл мөн.

Монголчуудын уламжлалт экологийн үзэлт бий болох явцад, нүүдлийн эдийн засгаас шийдвэрлэсэн уламжлалт үзэл санаа, соёл, шашин шүтлэг зэрэг нь мөн чухал үйлдэл гаргасан юм. XIII зуунаас өмнө, монголчуудын нийгэмд, бөөгийн шашны “Тэнгэр хүн нэгдмэл” үзэл нь хүмүүсийн үзэл санааны цар хүрээнд ноёрхох байрыг эзэлж, тэнгэр хүний харьцааны асуудалд, “Мөнх тэнгэрийн хүч”, “Мөнх тэнгэрийн хайр”-ыг итгэдэг монголчуудын үзэхээр, хүний амь насыг тэнгэр бий болгосноор барахгүй, хүн төрөлхтөний амьжиргааны түшиглэдэг бэлчээр, мал сүрэг, уул хайрхан, гол мөрөн, өвс мод, цэцэг навчис, жич зэрлэг амьтад зэргийг цөм дээд тэнгэрээс хайрласан юм байна. Хэрэв түүнийг хайрлаж нандигнахгүй юм бол, дээд тэнгэр хилэгнэж, биднийг шийтгэх нь дамжиггүй. Одоогийн үгээр хэлбэл, хүн байгалийн баялгийг ашиглах эрхтэй мөртөө хамгаалах хариуцлагатай, түүнийг эвдэж бүрэлгэх нь хамгийн их ял гэм мөн, эрт үеийн ан агнах, нүүдлийн эдийн засгийн үйлдвэрлэлийн хүчний хөгжилтийн хэмжээтэй тохиролцон бий болсон балар эртний шашин бөөгийн шашны баримтладаг “Тэнгэр хүн нэгдмэл” сургаалийн дотор бид “Тэнгэр хүн эетэй” байх хувьсангуй үзлийн үнэн ёсны оч гялалзаж байхыг олж үзэж болно.

Монголчуудын мал аж ахуй эзэгнэх урт удаан түүхэн явцад, маш олон хэв заншил, хориг цээрийг бий болгосон юм. Түүний дотор зарим хэв заншил, хориг цээр нь шинжлэх ухаанч болон өв уламжлалт чанар дутагдсанаас, нийгмийн соёл иргэншлийн хөгжлийн явцыг даган орхигдсон байна. Гэтэл зарим хэв заншил, хориг цээр бол нүүдлийн эдийн засаг гэсэн энэхүү онцгой эдийн засаг, соёлын төрх байдал доор

бий болсон хүн болон байгалийн харьцааг зохицуулж, хүмүүсийн үйл ажиллагааг хязгаарлах ёс суртахууны хэв намба болж, монголчуудын эртний үзэл санаа, соёл иргэншлийн өв хөрөнгө болсон бөгөөд бидний одоо үед залгамжилж бадруулах үндэстний уламжлалт соёлын сод өв болсон байна. Нүүдлийн соёлын нэг илт онцлог бол үйлдвэрлэлийн явцад эх байгалийг ер нь шууд эвдэхийг цээрлэж, тэртэй тэргүй түүнийг хамгаалан, хээр талын экологийн системийг урт хугацаагаар тэнцвэртэй байлгаж, хүн болон байгалийн эе эвтэй байхыг эрхэмлэдэг. Монголчуудын нүүдлийн эдийн засгийн хөгжлийн түүхийг үзэхэд, бид нэг талаар нүүдэллэн малжих экологийн эдийн засгийн орших нь уламжлалт экологийн үзэл суртлыг бий болгож, нөгөө талаар уламжлалт экологийн үзэл суртал нь эргээд экологийн эдийн засагт үйлчилж, иймэрхүү маягаар нүүдлийн эдийн засгийн экологижих явцыг түлхэн урагшлуулсан байна.

Мал сүрэг нь хөдөлмөрлөгчийн үйлдвэрлэл амьдралын олон талын эрэлт хэрэгцээг хангадаг жич солилцох нөхцөл муугаас шалтгаалж, мал аж ахуй эзэгнэдэг монголчууд таваарын эдийн засгийн үзлээр маш дутмаг байв. Харин байгалийг хамгаалах экологийн үзэл маш сайн. Энэ бол эдийн засгийн төрөл зүйлийн адилгүйгээс болсон таваарын үзэл болон экологийн үзлийн ялгаа байх. Одоогийн нөхцөлд, байгалийг хамгаалах, таваарын эдийн засгийг хөгжүүлэхийг хамтад нь анхаарч, давуу болон дутагдалтай талаа харилцан нөхвөрлөх нь чухал юм байна.